**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 25 Дугаар ЗТ-180/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо Чойжин ламын сүм музейн сэргээн засварын ажилд Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамж шийдвэрээр байгуулагдсан 6 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комисс 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн засварын ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: Байхгүй.

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр, дугаар: SP 08/2022M

2.3. Захиалагч: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9024070548, регистрийн дугаар: 6594204, хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Денверийн гудамж, Монголын Үндэсний Номын Сангийн шинэ байр Салбар номын сан, холбоо барих утас: 70188881, цахим хаяг: www.mocsty.gov.mn

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага: Зэндмэнэ суварга ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011143037, регистрийн дугаар: 2871076, Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ11-775/23, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Орхоны гудамж, 8-34 тоот, холбоо барих утас: 88113888, цахим шуудангийн хаяг: zendmene_suvarga2018@yahoo.com

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАСАГ
Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтанд оруулах комисс

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Сүлд проект ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011161123, регистрийн дугаар: 5249937, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар: ЗТ19-697/22, хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, 6 дугаар хороолол,47 байр 14 тоот, холбоо барих утас: 70114898, 91919318

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Чойжин ламын сүм музей, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9070004007, регистрийн дугаар: 1706845, хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Гэндэнгийн

Scanned with CamScanner

гудамж, холбоо барих утас: 70103232, цахим шуудангийн хаяг: templemuseum5@gmail.com

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

ХЯНАЛТ ША
ГАЗ
Барилга байгуулам
шинэчлэлтийн ажл
оруулах

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

☐ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай, СОЯ/202212017 гэрээний дугаартай, Чойжин ламын сүм музейн сэргээн засварын ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү засварын ажил нь зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

Scanned with CamScanner

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 3 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 12 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо Чойжин ламын сүм музейн сэргээн засварлалтын ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо,
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай
Чойжин ламын сүм музейн сэргээн засварын ажил

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичиг:
Зэндмэнэ суварга ХХК-ийн гүйцэтгэх захирал (С.Цэдэвсүрэн)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын
үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.
---o0o---

МЭДЭЭЛЛИЙН САН БҮРТГЭВ.
Объект № 523
Огноо 2025 он 12 сар 15 өдөр
Бүртгэсэн: О. Жинж
УЛААНБААТАР ХОТ

# ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН СЭРГЭЭН ЗАСВАРЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 дугээр сарын 16 Улаанбаатар хот

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтанд оруулах комисс

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай, СОЯ/202212017 гэрээний дугаартай, Чойжин ламын сүм музейн сэргээн засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссын хурал 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 17:00 цагт, тус газарт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдав.

Комиссын бүрэлдэхүүн:

1. Комиссын дарга:
   Хяналт шалгалтын газрын
   Барилга байгууламжийн ашиглалт,
   бүртгэлийн хэлтсийн даргын албан
   үүргийг түр орлон гүйцэтгэгч — А.Мөнгөн
2. Комиссын нарийн бичгийн дарга:
   Зэндмэнэ суварга ХХК-ийн гүйцэтгэх захирал — С.Цэдэвсүрэн

Комиссын гишүүд:

3. Ашиглагч байгууллага:
   Чойжин ламын сүм музейн захирал — Д.Отгонсүрэн
4. Зураг төсөл зохиогч байгууллага:
   Сүлд проект ХХК-ийн захирал — Г.Нямцогт
5. Нийслэлийн архивын газрын Улсын байцаагч — Б.Оюунжаргал
6. БХТ-ын ББЗХХ-ийн хяналтын инженер — Б.Мөнх-Эрдэнэ

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 6
- Хүрэлцэн ирсэн – 6
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 6

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай, СОЯ/202212017 гэрээний дугаартай, Чойжин ламын сүм музейн сэргээн засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд засварын ажлын зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Гүйцэтгэгч байгууллага: Зэндмэнэ суварга ХХК-ийн гүйцэтгэх захирал **С.Цэдэвсүрэн**

- Гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авахыг хүсэж байна.

Зураг төсөл зохиогч байгууллага: Сүлд проект ХХК-ийн захирал **Г.Нямцогт**

Scanned with CamScanner

- Чойжин ламын сүм музейн түүхийн дурсгалт барилга, Гол сүмийн 16 баганат асар, Хаалган сүм, Саравч, Махранзын сүм, Хэрмийг зураг төслийн дагуу сэргээн засварласан.
- Хуудас алтыг технологийн дагуу сайтар нааж гүйцэтгэсэн.
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ашиглагч байгууллага: Чойжин ламын сүм музейн захирал **Д.Отгонсүрэн**

- Комиссын гишүүдээс өгсөн санал зөвлөмжийг тусган баталгаат хугацаанд гүйцээж засаж дуусгах
- Сэргээн засварлалтыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх
- Сэргээн засварлалтын баримт бичгийг улсын архив болон музейн архивт хүлээлгэн өгөх.

БХТ-ын ББЗХХ-ийн хяналтын инженер **Б.Мөнх-Эрдэнэ**

- Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Архивын газрын архивын Улсын байцаагч **Б.Оюунжаргал**

- Хувийн хэргийн нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй өгөх
- Ажлын зургийг зургийн бүрдлийн дагуу бүрэн эх хувиар өгөх
- Ил далд ажлын акт, гэрэл зураг бүрэн бүрдүүлж дотоод товьёг хийх
- Засварын ажлын тэмдэглэл дэвтэр эх хувиар өгөх
- Төсөв эх хувиар бүрдүүлж өгөх
- Засварын ажилд хэрэглэсэн бараа материалын сертификат бүрэн бүрдүүлж дотоод товьёг хийж өгөх.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **А.Мөнгөн**

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу баталгаа албан тоот ирүүлэх
- Сэргээн засварлалт хийгдээгүй Хэрэм, зарим дам нуруу тайлбар ирүүлэх фото зургийн хамт
- Ажлын тоо хэмжээг актаар хүлээлцэх
- Баримт бичгийн 1 хувийг Чойжин ламын сүм музейд хүлээлцэх
- Дээврийн хагарч цуурсан хэсгийг засах /Махранзын сүм, шат тавьсан/
- Дээвэрт гардаг хэсэгт таг /модон/ хийх
- Махранзын сүмийн гадна, зүүн талын доод хэсгийн будаг засварлах
- Зохиогчийн тусгай зөвшөөрлийг хянуулах /эх хувиар/
- Төсөв хянуулах

Scanned with CamScanner

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ЗАХИАЛГАТАЙ, СОЯ/202212017 ГЭРЭЭНИЙ ДУГААРТАЙ, ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН СЭРГЭЭН ЗАСВАРЫН АЖЛЫГ КОМИССЫН ГИШҮҮДИЙН ГАРГАСАН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАХ, БИЕЛЭЛТЭЭР КОМИССЫН ДҮГНЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛЖ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХААР ШИЙДВЭРЛЭВ.

Танилцсан.
Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн.
Комиссын нарийн бичгийн дарга:
Зэндмэнэ суварга ХХК-ийн гүйцэтгэх захирал (С.Цэдэвсүрэн)

Scanned with CamScanner